

# НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ

2024 оны 06 дугаар сарын 17

Улаанбаатар хот

## **Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн байдал**

Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд 8 чиглэлээр ажилчдын нийгмийн асуудлыг дотоод нөөцдөө нийцүүлэн шийдвэрлэн ажиллаж байна

### **Ажлын байр, нийгмийн баталгаа:**

Хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажлын байрны тодорхойлолтоо биелүүлэн ажиллаж байгаа ажилтнуудын ажлын байрны баталгааг ханган ажиллаж байна.

2024 онд байгууллагын бүтэц, орон тоо нэмэгдсэнтэй холбоотойгоор нийт 12 шинэ ажлын байрыг төвийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан ба 19 ажилтан сонгон шалгаруулалтад орсон бөгөөд 14 ажил горилоч ажлын байранд тэнцсэн байна. Байгууллагын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдон 8 ажлын байрны тодорхойлолтод шинэчлэл хийж, шинээр 6 ажлын байрны тодорхойлолт боловсруулсан байна.

Засгийн газрын тогтоол болон төвийн даргын тушаалтай холбоотойгоор нийт 30 ажилтны хөдөлмөрийн гэрээг шинэчлэн хуулийн хугацаанд гэрээ байгуулсан. Засгийн газрын 2024 онд гарсан 84 болон 128 дугаар тогтоолтой холбоотойгоор нийт 30 ажилтны хөдөлмөрийн гэрээний хавсралтыг боловсруулж баталгаажуулалт хийсэн байна.

2024 оны эхний хагас жилд 7 ажилтан захиргааны чөлөө авч, 2 ажилтан хичээлийн хуваарийн дагуу гарагийн чөлөө авсан байна. Цалин хөлсний батлагаа 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн А/07 тоот тушаалаар төвийн ажилтнуудын 2024 оны бүтэц, цалин цалингийн шатлалыг батлуулан ажилласан.

Нийт ажилтнуудын ажлыг улирлаар дүгнэж 2024 оны эхний 2 улиралд ур чадварын нэмэгдэл олгох журмын дагуу ур чадварын нэмэгдэл олгогдсон. Ажилтнуудын үр дүнгийн үнэлгээгээр эхний хагас жилийн ур дүнгийн урамшуулал 7 дугаар сард олгогдоно. Мөн бүх нийтийн амралтын өдрөөр ажилласан ажилтнуудад илүү цагийн хөлсийг тооцон олгосон.

### **Нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна.**

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхийн тулд ажилтнуудын талаарх суурь судалгаа гарган ажилласан. Үүнд:

1. Төвийн ажилтнуудын амьдарч буй орон байрны судалгаа,
2. Албан хаагчдын 2024-2025 оны боловсролын хөгжлийн судалгаа
3. Нийгмийн баталгааны зардлын дундаж тооцооллын судалгаа
4. Ажлын байран дах ажилтнуудын нас хүйсийн тэнцвэрт байдлын судалгаа

Дээрх судалгаанд үндэслэн нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:

1. Сургалт хөгжлийн чиглэлээр дэмжлэг үзүүлсэн -1 ажилтан
2. Гэр бүлийн тогтвортой байдлын хангах ажлын хүрээнд-1 ажилтан
3. Нийгмийн баталгааг хангах үүднээс 5 ажилтанд дэмжлэг үзүүлэн ажилласан байна.

Төвийн нийт 7 ажилтан нийгмийн баталгааны хөтөлбөрийн хүрээнд дэмжлэг тусламж авсан байна.

Ажилтан албан хаагчдыг урамшуулах, ажлын байрны тогтвортой байдлыг хангах үүднээс Төвийн даргын дэмжлэг, тусламжаар 7 ажилтныг 2024 оны 04 сарын 26-наас 5 хоног Бээжин хотын аялалд хамруулсан.

### **Эрүүл мэндийн баталгаа:**

Ажлын байр төрөл бүрийн халдварт өвчний эрсдэл ихтэй, албан хаагчдын стрессийн нөхцөл байдал өндөр тул ажилтнуудыг хагас жилд нэг удаа нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж шаардлагатай тохиолдолд дараагийн шатлалын эмнэлэгт шинжилгээ хийлгэхэд нь цагийн чөлөө олгож ажилладаг.

2024 онд сүрьеэгийн үзлэг шинжилгээнд нийт 17 ажилтан хамрагдсанаас нас эрүүл 16, давтан үзүүлэх-1 ажилтан тус тус оношлогдсон байна. 2024 оны сүүлийн хагас жилд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулахаар бэлдэж байна. Цаашид албан хаагчдын ажлын ачааллыг бууруулах, эрүүл мэндээ дэмжихэд нь цаг гаргах дархлаа дэмжих хөтөлбөр хэрэгжүүлэх шаардлагатай байна.

### **Ажиллах нөхцөлийн баталгаа:**

Ажиллах нөхцөл нь орчны болон сэтгэл зүйн хувьд эрсдэл өндөр байдаг.

2024 онд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөний өрөө, иргэдтэй ганцаарчлан уулзах өрөө, шинээр ажиллуулснаар албан хаагчдын ажлын орчны нөхцөл сайжирсан. Мөн ажилтнуудад зориулан амралтын өрөөг тохижуулан ашиглалтад оруулсан. Цаашид эмчийн үзлэгийн өрөөний агааржуулалтыг сайжруулснаар ариун цэвэр халдвар хамгааллын нөхцөл дээрдэх боломжтой юм.

### **Сурч боловсрох баталгаа:**

Албан хаагчдын боловсролын зэргээр судалгаа хийхэд дипломын дээд боловсролтой болон бакалаврын зэрэгтэй 18, тусгай дунд, бүрэн дунд-12 үүнээс эрдмийн зэргийн хувьд докторант-1, магистр-2 магистрант-1 тус тус байна.

Ажилтнуудад ажлын байрандаа болон сургалтын төв, их дээд сургуульд суралцан мэдлэг боловсролоо дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цалинтай чөлөө олгох төлбөрийн дэмжлэг үзүүлэн ажилладаг. Хүний нөөцийн сургалтын чиглэл тодорхойлох судалгааг боловсруулан үр дүнг тооцон албан хаагчдад танилцуулсан.

Шинэ албан хаагч нарт зориулсан байгууллагын танилцуулга төлөвлөгөө гаран батлуулж, нийт 9 шинэ ажилтанд байгууллагын зорилго, зорилт, үнэт зүйл, хэтийн зорилго, төвийн үндсэн үйл ажиллагаа, нийгмийн даатгал, цалин хөлс, илгэх хуудас бичих загвар зэргийг танилцуулсан үйл ажиллагааг зохион байгуулсан.



Ажлын орон тооны нөхөлтөөр авсан шинэ ажилтанд байгууллагын үйл ажиллагаа, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг танилцуулан хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2024 оны эхний хагас жилд “Хүний нөөцийн хөгжлийн төв”-өөс зохион байгуулсан сургалтад давхардсан тоогоор нийт 43 ажилтан, 148 цагийн хувь хүний хөгжлийн болон мэргэжлийн чиглэлээр сургалтад хамрагдсан байна.

Хагас жилд Нийгмийн хамгааллын тусгай төвөөс зохион байгуулсан 8 цагийн эрүүл мэндийн, хуулийн 2 цагийн сургалтад ажилтан, албан хаагчид тус тус оролцсон бөгөөд давхардсан тоогоор нийт 119 албан хаагч хамрагдсан байна.

Хүний хөгжлийн сургалтад хамрагдсан нийт 23 албан хаагч (давхардсан тоогоор) 3 цаг 50 минутын танилцуулга хичээл зохион байгуулж сурсан мэдлэгээ бусадтайгаа хуваалцсан байна.



### **Хүний нөөцийн гүйцэтгэлийн удирдлага, хамтын үйл ажиллагаа:**

Төвийн ажилчдын ажил хүлээлцэх, ур чадварын нэмэгдэл олгох, үр дүнгийн урамшуулал олгох журмуудыг тус тус шинэчлэн боловсруулж батлуулсан.

Төвийн их эмч, арга зүйч нар “Активмед” архины хамааралтай иргэнд үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн үйл ажиллагаатай танилцан, туршилга судалсан.

2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 407 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн “Эх үрс-Итгэлт ирээдүй” өдөрлөгт мэдээлэл өгч хамтран ажилласан



2024 оны 03 дугаар сарын 10-ны өдөр Сонгино хайрхан дүүргийн 35-р хорооны эмэгтэйчүүдэд зориулсан “Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд 1 цагийн сургалт, танилцуулга хийж хамтран ажилласан.

2024 оны 5 сарын 15-ний өдөр Тус төвөөс Налайх, Багануур, Багахангай дүүргийн Засаг дарга нар, Нийгмийн хөгжил, Хөдөлмөр халамж, Цагдаагийн хэлтэс зэрэг холбогдох байгууллагуудын төлөөллүүдийн уулзалтад мэдээлэл танилцуулга хийж, туршлага солилцон хамтран ажилласан.



Төвийн хамтын үйл ажиллагааны хүрээнд нийт 16 төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран “Нийгмийн хамгааллын тусгай төвийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, цаашдын хөгжил хамтын ажиллагаа” хэлэлцүүлэг зохион байгуулахад хамтран ажиллаж танилцуулга мэдээлэл хийсэн.

### **Амьдралын түвшний судалгаа ба баталгаа:**

Төвийн нийт 30 ажилтны амьдарч буй орчны судалгаа гаргасан бөгөөд график 1-т харууллаа. Цаашид хүний нөөцийн амьдралын нөхцөл байдлыг дээшлүүлэх, түрээслээд өмчлөх хэлбэрийн орон сууцанд хамруулахад анхаарч ажиллах шаардлагатай байна.



**Амрах эрхийн баталгаа:**

Албан хаагчдын санал, байгууллагын ажлын ачааллыг харгалзан жил бүрийн эхэнд ээлжийн амралтын хуваарийг баталж хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх ажлыг зохион байгуулдаг. 2024 оны А/23 дугаартай тушаалаар төвийн ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг баталж, 7 дугаар сараас 10 дугаар сард ажилтнууд ээлжийн амралтаа авахаар төлөвлөсөн байна.

Албан хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх чиглэлээр байгаль орчинтой танилцах эрүүл агаарт идэвхтэй алхах амралтыг жилд 1-2 удаа зохион байгуулдаг. Төвийн албан хаагчдын амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлж, нийтэч хамт олонч харилцаанд татан оролцуулж, явган аяллаар дамжуулан эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Явган аялал" арга хэмжээг 2 удаа зохион байгуулсан. Мөн гадаад улсад хувийн зардлаараа аялалд хамрагдах болзол хангасан төвийн 2 ажилтанд нийгмийн баталгааны хөтөлбөрийн дагуу нийт 5 өдрийн цалинтай чөлөө олгож дэмжиж ажилласан.

**Бусад баталгаа:**

Төвийн дотоод журмын дагуу ажилтнуудад тэтгэмж дэмжлэг олгон ажиллаж байна.

Эх үрсийн баярын арга хэмжээг тохиолдуулан нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 30 ажилтны 26 хүүхдэд нийт 1.300.000 төгрөгийн бэлэг өгсөн. Сар шинийн баяраар төвийн ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэн 750.000 төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.